



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар A/144

Ховд

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх Жаргалант сумын дулааны хуучирч муудсан шугамын засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүд: О.Эрдэнэсүрэн – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Өлзийбат - Хувийн хэвшлийн төлөөлөл

Г.Сүнжидмаа – Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Г.Нэмэхбаяр – Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэг үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Г.Нэмэхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



02 00601  
D/A/144-Da